

22 МЕССИА: Амилсан Аврагч

22. 1 Авралын хүч

[] Үхлийн хүчийг залгиж, Сүмийг худалдан авч, (дайснаас дээгүүрх эрх мэдэл –Есүсийн хүчирхэг нэр) үхэл болон амилалтад итгэдэг бидэнд Өөрийн нэрийг өгсөн.

¹⁰Би тэнгэрт чанга дуугаар ингэж хэлэхийг сонсов.-Бурханы өмнө ах дүүсийг маань өдөр шөнөгүй буруутгадаг тэднийг буруутгагч доош хаягдсан учраас эдүгээ бидний Бурханы аврал, хүч, хаанчлал ба Түүний Христийн эрх мэдэл хүрч ирлээ. ¹¹Тэд түүнийг Хурганы цус, өөрсдийн гэрчлэлийн үгээр ялжээ. Тэд үхэн үхтлээ амиа хайрлаагүй юм. ¹²Тиймээс тэнгэр ээ, тэнд нутаглагсад аа, баярлан хөөрөгтүн. Газар ба тэнгис золгүй еэ! Яагаад гэвэл диавол үлэмж их уур хилэнтэйгээр та нар уруу бууж ирсэн. Өөрт нь богинохон хугацаа байгааг тэр мэдэж байгаа. (Илчлэлт 12:10-12 АБ 2004)

22.2 Цөлийг бэлчээр болгосон.

Хүмүүсийн төлөөх гэрээ ба харь үндэстнүүдийн төлөөх гэрэл

⁵Тэнгэрийг бүтээж татаад,
дэлхий болон түүний үр жимсийг дэлгэсэн,
түүн дээрх хүмүүст амьсгал өгөгч,
түүний дотор явагчдад сүнснийг өгөгч Бурхан ЭЗЭН ингэж
айлдаж байна.

⁶“Би бол ЭЗЭН.

Би чамайг зөвт байдалд дуудсан.

Би бас чиний гараас атгаад,
чамайг хамгаална.

Би чамайг ард түмний гэрээ болгож,
үндэстнүүдийн гэрэл болгоно.

⁷Энэ нь сохрын нүдийг нээн,

гяндангаас хоригдлуудыг чөлөөлж,

харанхуйд суугчдыг шоронгоос гаргахын тулд юм. (Исаиа
42:5-7 АБ 2004)

⁶Тэр “Иаковын овгуудыг босгон, Израилийн нөөцлөгдөгсдийг сэргээхийн тулд чи Миний Зарц байх нь өчүүхэн хэрэг. Би мөн Өөрийн авралыг газрын хязгаарт хүргэхийн тулд Чамайг үндэстнүүдийн гэрэл болгоно”.
(Исаиа 49-6 АБ 2004)

¹Зэлүүд газар, цөл баярлан, Араба ч баясан, замар цэцэг мэт дэлгэрнэ. ²Энэ нь цэцэглэн сагсайж, цэнгэн баясаж, баяр хөөртэйгөөр хашхирна. Ливаны алдар, Кармел ба Шароны сүр хүч түүнд өгөгдөнө. Тэд ЭЗЭНий алдар, бидний Бурханы цог жавхланг харна. ³Тэнхэлгүй гарыг хүчтэй болгон, суларсан өвдгийг бататгагтун.

⁴Хулчгар зүрхтнүүдэд “Зоригтой бай. Бүү ай. Үзэгтүн, та нарын Бурхан өшөө авахаар ирнэ. Бурхан хариуг нь өгөхийн тулд ирэхдээ та нарыг аварна” гэж хэлэгтүн. ⁵Тэгээд сохрын нүд нээгдэж, дүлийгийн чих нь онгойно. ⁶Тэгээд доголлон хүн буга мэт дүүлж, хэлгүй нь баяртайгаар хашхирна. Учир нь цөлөөс ус гарч, Арабад урсана. ⁷Хатсан газар цөөрөм болж, цангасан газарт ус ундран, цөөвөр чонын үүр хоноглох газруудад өвс ургамал хулс, зэгснүүд ургана. (Исаиа 35:1-7 АБ 2004)

[] Бурхан бол амь ба үхлийн цорын ганц хаалгач гэдэгт та итгэдэг үү?

[] Есүс Христ болон Сайн мэдээ төлөвлөсний дагуу тунхаглагдсан байх болно гэдгийг та мэдэх үү?

[] Та энэхүү үйл явдалд оролцохыг хүсэж байна уу ?

22.3 Үргэлж таны өмнө

¹¹Явагтун, явагтун. Тэндээс гарагтун!
Бузар юманд бүү хүрэгтүн!
Түүний дундаас гарагтун!
ЭЗЭНий савнуудыг тээгчид ээ, өөрсдийгөө ариусгагтун!

¹²Харин та нар бүү яарч гар, оргодол мэт бүү зугтагтун.
Учир нь ЭЗЭН та нарын өмнө явна.
Израилийн Бурхан та нарын ар талыг хамгаална. (Исаиа 52:11-12 АБ 2004)

[] Тэрээр тулаанд үргэлж та нарын өмнө явдаг гэдгийг та мэдэх үү?

22.4 Үхэгсдээс босох болно!

¹⁰Учир нь Та миний сэтгэлийг Үхэгсдийн оронд орхихгүй. Та Өөрийн Ариун Нэгэнд ч ялзрахыг зөвшөөрөхгүй. (Дуулал 16:10 АБ 2004)

¹⁶Хэн итгэж баптисм хүртэнэ, тэр аврагдах болно. Харин итгээгүй хүн нь яллагдах болно. (Марк 16:6 АБ 2004)

³¹Христийн амилалтыг угтан харж, “Тэр Үхэгсдийн оронд орхигдсонгүй, Түүний махан бие ялзралыг ч үзсэнгүй” гэжээ. (Үйлс 2:31 АБ 2004)

22.5 Тэнгэр өөд гарах

¹⁸Та өндөрт гарч, олзлогдогсдыг дагуулжээ. Та хүмүүсийн дунд бэлэг авсан, Тэрслэгчдээс ч авсан нь ЭЗЭН Бурхан тэнд оршин суухын тулд юм. (Дуулал 68:18 АБ 2004)

⁹Тэр ийнхүү айлдсаны дараа тэднийг харж байхад нь дээш өргөгдөж үүлэнд орж тэдэнд харагдахгүй болов. (Үйлс 1:9 АБ 2004)

[] Бурхан ямар учраас тааламжит тахилыг хүсдэгийг та мэдэх үү?

22.6 Бурханы баруун гар талд суух

¹ЭЗЭН миний Эзэнд “Би чиний дайснуудыг хөлийн чинь гишгүүр болгох хүртэл Миний баруун гар талд суу” гэдэг. (Дуулал 110:1 АБ 2004)

³Хүү нь Түүний алдрын туяа, Түүний мөн чанарын бодит илэрхийлэл бөгөөд Өөрийн хүчит үгээр бүхнийг барьдаг болой. Тэр нүглүүдийн ариусгалыг гүйцээгээд, дээр байгч Сүр жавхлант Нэгэний баруун гарт залрав. (Еврей 1:3 АБ 2004)

¹Арлууд аа. Намайг сонсогтун. Алс холын хүмүүс ээ, анхаарагтун. Хэвлийд байхаас минь ЭЗЭН Намайг дуудсан. Эхийнхээ

дотор байхаас минь Тэр Намайг нэрлэсэн. ²Тэр Миний амыг хурц илд мэт болгон, мутрынхаа нөмөрт Намайг далдалж, шилмэл сум мэт болгон, саадаг дотроо Намайг нуусан. ³Тэр Надад “Израиль аа. Чи Миний Зарц. Чиний дотор Би Өөрийгөө алдаршуулна” гэж айлдав. ⁴Харин Би “Би дэмий хөдөлмөрлөж, Өөрийн хүчийг юунд ч биш, хоосон зарцуулжээ. Гэвч үнэхээр Миний авах зүйл бол ЭЗЭНТэй хамт, Миний шагнал бол Бурхантай минь хамт юм” гэсэн. (Исаиа 49:1-4 АБ 2004)

¹⁴Та нар бүгдээрээ цуглаж, сонсогтун. Тэднээс хэн нь эдгээр зүйлсийг тунхагласан бэ? ЭЗЭН түүнийг хайрладаг. Тэр Түүний сайн тааллыг Вавилон дээр авчирна.Түүний мутар халдеичуудын эсрэг байна. ¹⁵Би, зөвхөн Би айлдсан. Үнэхээр Би түүнийг дуудсан. Би түүнийг авчирсан бөгөөд Тэр түүний замыг өлзийтэй байлгана. ¹⁶Надад ойртон ирээд, үүнийг сонсогтун! Би эхнээсээ нууцаар яриагүй.Энэ явдал болох үеэс Би тэнд байсан юм. Одоо Эзэн БУРХАН Намайг болон Өөрийн Сүнсийг илгээв”. (Исаиа 48:14-16 АБ 2004)

⁵⁴Үүнийг сонссон тэдний хорсол буцалж, шүдээ хавирч байлаа. ⁵⁵Харин Ариун Сүнсээр дүүрсэн Стефан тэнгэр өөд ширтэн Бурханы суу алдрыг болон Бурханы баруун талд зогсож буй Есүсийг хараад, ⁵⁶-Харагтун. Тэнгэр нээгдэхийг болон Бурханы баруун талд зогсож байгаа Хүний Хүүг би харж байна гэж хэлэв. (Үйлс 7:54-56 АБ 2004)

[] Тэр яаж ингэж байгааг та мэдэх үү?

[] Сүнсний удирддаг бүх үйлчлэлийн ажил амжилттай болно гэдэгт итгэдэг үү?

22.7 Аврахын тулд Тэр мөнх амийг соёрхсон

⁴⁵Эцэгийн өмнө Би та нарыг буруутгана гэж бүү бод. Та нарыг буруутгагч бол та нарын найдвараа тавьсан Мосе мөн. (Иохан 5:45 АБ 2004)

¹³Тэнгэр ээ, баярлан орилогтун. Газар аа, баясагтун. Уулс аа, бахдан дуулагтун. Учир нь ЭЗЭН Өөрийн ард түмнээ тайвшруулсан бөгөөд Өөрийн зовсон хүмүүсийг энэрэх болно. (Исаиа 49:13 АБ 2004)

¹Харин Есүс Чидун уул уруу явав. ²Өглөө эрт Түүнийг сүмд дахин ирэхэд, хүмүүс бүгд Түүн уруу ирцгээв. Тэр сууж, тэднийг сургаж эхлэв.

³Хуулийн багш нар болон фарисайчууд завхайрч байгаад баригдсан нэгэн эмэгтэйг авчраад голдоо зогсоов. ⁴Тэд Есүст -Багш аа, энэ эмэгтэйг завхайрч байхад нь үйлдэл дээр нь барьсан юм. ⁵“Ийм эмэгтэйчүүд уруу чулуу шидэгтүн” гэж Мосегийн Хуульд тушаасан. Харин Та юу гэж хэлэх вэ? гэцгээв.

⁶Тэд Есүсийг буруутгах шалтаг хайхын тулд Түүнийг сорин ийнхүү асуужээ. Гэтэл Есүс бөхийж, хуруугаараа газарт бичив.

⁷Харин тэд зогсоо зайгүй асуусанд Есүс цэх зогсоод тэдэнд - Та нарын дундаас нүгэлгүй хүн нь эхлээд энэ эмэгтэй уруу чулуу шид гээд, ⁸Тэр дахин бөхийж, газарт бичив.

⁹Үүнийг сонсоод, тэд ахмадуудаасаа эхлэн нэг нэгээрээ гарч явсаар ганц Есүс л үлджээ. Өнөөх эмэгтэй тэндээ зогссоор л байв. ¹⁰Есүс цэх зогсож, тэр эмэгтэйд -Эмэгтэй, тэд хаана байна? Чамайг хэн ч шийтгэсэнгүй юу? гэсэнд ¹¹тэр -Эзэн, хэн ч шийтгэсэнгүй гэв. Есүс -Би ч чамайг шийтгэхгүй. Яв. Үүнээс хойш дахин нүгэл бүү үйлд гэлээ. (Иохан 8:1-11АБ 2004)

²⁸Эцэж туйлдсан, хүнд дарамт үүрсэн хүмүүс ээ, бүгд Над уруу ир. Би та нарыг амраая. (Матай 11: 28 АБ 2004)

³⁷Эцэгийн Надад өгдөг бүхэн Над уруу ирнэ. Над уруу ирэх хүнийг Би огт хөөж гаргахгүй. (Иохан 6:37АБ 2004)

⁴⁰Учир нь Хүүг харж, Түүнд итгэгч бүр мөнх амьтай байх нь Миний Эцэгийн хүсэл юм. Эцсийн өдөрт Би Өөрөө Түүнийг амилуулна гэж айлдлаа. (Иохан 6:40АБ 2004)

⁴⁴Намайг илгээсэн Эцэг хэн нэгнийг татахгүй л бол хэн ч Над уруу ирж чадахгүй. Би тэр хүнийг эцсийн өдөрт амилуулна. (Иохан 6:44 АБ 2004)

⁵¹Би бол тэнгэрээс бууж ирсэн амьд талх байна. Хэрэв хэн нэгэн энэ талхнаас идвэл, тэр мөнхөд амьдарна. Ертөнцийн амийн төлөө Миний өгөх талх бол Миний махан бие юм гэж айлдлаа. (Иохан 6:51 АБ 2004)

⁵⁴Миний махыг идэж, цусыг уусан хүн мөнх амьтай бөгөөд Би түүнийг эцсийн өдөрт амилуулна. (Иохан 6:54 АБ 2004)

¹²“Таны нэрийг Би Өөрийн ах дүү нарт тунхаглана, Чуулганы дунд Таныг Би магтан дуулна”, (Еврей 2:12 АБ 2004)

⁵Сэнтийд Залрагч-Харагтун, Би бүх юмсыг шинэ болгож байна гээд -Бичигтүн, эдгээр үгс итгэмжит бөгөөд үнэн гэв.

⁶Тэр надад -Биеллээ. Би бол Альфа ба Омега, Эхлэл ба Төгсгөл. Цангасан нэгэнд Би амийн усны булгаас үнэгүй өгнө.

⁷Ялагч нь эдгээр зүйлийг өвлөх бөгөөд Би түүний Бурхан болж, тэр Миний хүү болно. ⁸Харин хулчгар, итгэлгүй, жигшүүрт, алуурчид, завхай хүмүүс, мэргэ төлөгчид, шүтээнд мөргөгчид болон бүх худалч хүмүүсийн хувьд, тэдэнд оногдох хувь нь хоёр дахь үхэл буюу хүхэр, галаар шатаж буй нуурт байна гэв. (Илчлэлт 21:5-8 АБ 2004)

- Түүний мөнхийн тайтгарал ирж байгаа гэдэгт та итгэдэг үү?
- Таньд мөнх амь бий юу?
- Та өдөр бүр амийн талх иддэг үү?
- Та хуучин биш, шинэ амьдралаар амьдарч байна уу?
- Та сорилтыг давж байна уу?
- Их Эзэнээс эмээх гэдэг нь нүглийг үзэн ядах юм гэдгийг та мэдэх үү?